



1925

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/361

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дахь заалт, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO27001:2023 стандарт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 3 дугаар зүйлийн 3.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг нэгдүгээр хавсралтаар, Мэдээллийн аюулгүй байдлын хяналтын бодлогыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалыг 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (О.Чойдог)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.БЯМБАСҮРЭН

141252282

	МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН БОДЛОГО		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2025/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-МТА-БМСЗХЖ-.....

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын 2025 оны *08* дугаар сарын *08*-ны өдрийн *АБ66* дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

Эмнэлгээр үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан тухай мэдээлэл болон байгууллагын мэдээллийн нууцлал, хүртээмжтэй байдал, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор ISO/IEC 270001:2023 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хянах, тасралтгүй сайжруулж, нутагшуулахад дараах зарчмыг баримталж ажиллана. Үүнд:

1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд олон улсын стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.
2. Хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэхийн тулд хэрэгцээтэй мэдээллээр хангах, сургалтанд хамруулах, эрсдлийн үр дагаврыг таниулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.
3. Бид байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эрсдлийг тогтмол давтамжтай үнэлж, өндөр нөлөөтэй эрсдэлүүдэд тохирсон хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, мэдээллийн аюулгүй байдлын эрсдлүүдийг хяналтдаа авах, бууруулах чиглэлээр анхаарч ажиллана.
4. Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны үр дүнтэй байдал, хэрэгжилтэд дотоод аудитыг тогтмол давтамжтай гүйцэтгэж, хэмжигдэхүйц үр дүнд үндэслэн тасралтгүй сайжруулна.

----- ооо ООО ооо -----